

**МОНГОЛ УЛСЫН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН
САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН
2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ИРЭЭДҮЙН ӨВ САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХОЁР ДАХЬ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН ТАЛААРХ
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
САНАЛ, ДҮГНЭЛТ**

2021 оны 10 дугаар
сарын 26-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан

Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2022 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хийж, хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороод, Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд шилжүүлсэн билээ.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2021 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 70 дугаар зүйлд заасны дагуу төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийлээ.

Байнгын хорооны хуралдаанаар төсвийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат Гадаад харилцааны яамны төсөвт 2022 онд шинээр элчин сайдын яам, консулын газар байгуулагдахаар төлөвлөсөн эсэх, гадаад улсад томилогдон ажиллах ажилтнуудын орон тоо нэмэгдэж байгаа эсэх, цаашид Гадаад харилцааны яам, гадаад харилцаа, гадаад аюулгүй байдлын талаарх асуудлуудыг дэмжин ажиллах талаар болон Батлан хамгаалах яамны төсөвт кибер аюулгүй байдлын цэргийн командлалын төсөв орж ирснийг дэмжиж, цаашдын үйл ажиллагаа, хангамж, боловсон хүчний талаар, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьшaa Гадаад харилцааны яамны гадаад томилолтын зардал 350 сая төгрөгөөр, Хөрөнгө оруулалтын судалгааны төвийг Гадаад харилцааны яамны дэргэд байгуулахаар шийдвэрлэсний дагуу мэдээлэл сурталчилгааны зардал 400.0 сая төгрөгөөр өссөн талаар, цаашид үргүй зардлыг хэмнэхэд анхаарч ажиллах, Монгол Улсыг гадаад улсад төлөөлөх дипломат ажилтнуудын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх болон үндэсний аюулгүй байдал, эдийн засаг, аялал жуулчлалыг гадаадад сурталчлах талаар ямар ажил, зарчмын өөрчлөлтийг хийхээр тусгасан талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр төсвийн орлогыг нэмэгдүүлэх, баялагийн менежментийг хийх, татварын шинэчлэлийг оновчтой хийх, алсын хараа 2050 хөгжлийн баримт бичигт дотоодын нийт бутээгдэхүүнд батлан хамгаалах салбарын зардлын эзлэх хувь 2020 оны байдлаар суурь түвшин 0.7 хувь, 2030 онд 1.5 хувьд хүргэнэ гэж төлөвлөсөн нь 2022 оны төсвийн төсөлд хэдэн хувиар тооцсон талаар, гадаад улсад суугаа дипломат ажилтнуудын цалинг нэмэгдүүлэх, ахуй хангамжийг сайжруулах талаар, Онцгой байдлын ерөнхий газар болон Цөмийн энергийн комиссын төсөв хичнээн

төгрөгөөр нэмэгдсэн талаар Байнгын хорооны эрхлэх асуудлын хурээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, хариулт авсан болно.


Байнгын хорооны хуралдаанаар төсвийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Б.БАТТӨМӨР